



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

20²² он 07
сарын 05 өдөр

Дугаар 35-1/107

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАР ТАНАА

Тогтоолын төсөл өргөн
мэдүүлэх тухай

“Хөгжлийн зорилтот хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгөхийг хүсье.



Монгол Улсын Ерөнхий сайд

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

000224000984



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20 ^{дд} он ^{дд} дугаар
сарын ^{дд} -ны өдөр

Дугаар ^{хэр} / 1581

Улаанбаатар-12
Утас 260817
Факс 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Л.ӨЛЗИЙСАЙХАН ТАНАА

Тогтоолын төсөл өргөн мэдүүлэх
хугацааг товлох тухай

“Хөгжлийн зорилтот хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын
төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Улсын Их Хуралд өргөн
мэдүүлэхээр тогтсон тул холбогдох материалыг хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгөхийг хүсье.

Хавсралт ^{дд} хуудастай.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



Ц.НЯМДОРЖ

000225007492

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн хуралдааны 35 дугаар тэмдэглэлд:

“ХХII.ХЭЛЭЛЦСЭН нь: “Хөгжлийн зорилтот хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: “Хөгжлийн зорилтот хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Б Ширэндэвийн гудамж 8/4, Засгийн газрын V байр,
Утас/Факс: (976-51) 26 75 33, И-мэйл: info@mjha.gov.mn,
Вэбсайт: www.mjha.gov.mn

додд. 06.30 № 1/3691
танай -ны № 11/673 -т

**САНГИЙН САЙД БӨГӨӨД ЭДИЙН
ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙДЫН ҮҮРЭГ
ХАРИУЦАГЧ Б.ЖАВХЛАН ТАНАА**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасныг үндэслэн "Хөгжлийн зорилтот хөтөлбөр батлах тухай" Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.



Х.Н. БААТАР

1516033.0
А5 Файл.2022



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/факс: (976-51) 26-74-68, <http://www.mof.gov.mn>

2022.06.30 № 01/4661

танай 2022.08.27 -ны № 02/638 -т

**МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ
ГАЗРЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ
ТАНАА**

“Хөгжлийн зорилтот хөтөлбөр батлах тухай”
Улсын Их Хурлын тогтоолын төслийг Хууль
тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7
дахь хэсэгт заасныг үндэслэн Улсын Их Хуралд
өргөн мэдүүлэх зөвшөөрлийг үүгээ олгож байна.

Хүндэтгэсэн


Б.ЖАВХЛАН

9761000881



**“ХӨГЖЛИЙН ЗОРИЛТОТ ХӨТӨЛБӨР БАТЛАХ ТУХАЙ”
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН
ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Тогтоолын төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтад “Хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна.” гэж заасан.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалтад “Хөгжлийн зорилтот хөтөлбөр гэж Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тусгагдсан тодорхой зорилт, арга хэмжээг улсын хэмжээнд хэрэгжүүлэхээр салбар, салбар хоорондын болон бүс, орон нутгийн онцлогт нийцсэн, нөөцөд суурилсан, санхүүгийн эх үүсвэрээр баталгаажсан үйл ажиллагаа, тоон болон чанарын шалгуур үзүүлэлтийг тусгасан дунд хугацааны бодлогын баримт бичгийг” гэж, мөн хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.2 дахь заалтад энэ хуулийн 4.1.5-д заасан баримт бичгийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэг, Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д заасныг тус тус баримтлан Улсын Их Хурал батлахаар заасан.

1.2.Практик шаардлага

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулга нь Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлт, тэдгээрийн уялдаа, хоорондын нийцлийг хангаж, түүнийг боловсруулан батлах тогтолцоог бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг баталсан. Уг хөгжлийн бодлогын баримт бичиг нь Монгол Улсын ирээдүйн 30 жилийн хөгжлийг тодорхойлсон, Монголын эзэнт гүрний түүх, нүүдэлчин соёл иргэншил, үндэсний давтагдашгүй онцлогт суурилж, дэлхийн хөгжлийн дэвшилтэт үзэл баримтлалтай хослуулсан “Монгол хөгжлийн загвар” юм.

“Алсын хараа-2050” хөгжлийн бодлого нь 2030, 2040, 2050 он хүртэл 3 үе шаттайгаар хэрэгжих бөгөөд эхний үе шатны 2030 онд хүрэх үр дүнг хангахад чиглэсэн дунд хугацааны Хөгжлийн зорилтот хөтөлбөрийг боловсруулахыг Улсын Их Хурлаас Засгийн газарт үүрэг болгосон. “Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний

удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” Монгол Улсын Их Хурлын 2021 оны 10 дугаар тогтоолоор Засгийн газарт өгсөн чиглэлийн дагуу хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт дүн шинжилгээ хийж, үе шаттайгаар хуульд нийцүүлэх арга хэмжээг авсан.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэхэд чиглэсэн зорилго, зорилт, санхүүгийн эх үүсвэр, үйл ажиллагаа, тоон болон чанарын шалгуур үзүүлэлт бүхий Хөгжлийн зорилтот хөтөлбөрүүд байх бөгөөд Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд дараах 7 зорилтот хөтөлбөрийг боловсруулахаар заасан. Үүнд:

- 1.хүний хөгжлийн зорилтот хөтөлбөр;
- 2.нийгмийн хөгжлийн зорилтот хөтөлбөр;
- 3.эдийн засгийн болон дэд бүтцийн хөгжлийн зорилтот хөтөлбөр;
- 4.байгаль орчны зорилтот хөтөлбөр;
- 5.засаглалын зорилтот хөтөлбөр;
- 6.бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөр;
- 7.үндэсний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилтот хөтөлбөр.

Үүнээс Эдийн засгийн болон дэд бүтцийн хөгжлийн зорилтот хөтөлбөр нь Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-д бүрэн тусгагдсан болно. Энэ нь эдийн засаг, дэд бүтцийн салбарын хөгжлийн хязгаарлагч хүчин зүйлүүдийг тодорхойлж, шийдвэрлэхээр зорьсон эхний зорилтот хөтөлбөр нь болно.

Хоёр.Тогтоолын төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Тогтоолын төсөл нь 5 заалттай байх бөгөөд тогтоолын төслийн 1 дэх заалтаар Хөгжлийн зорилтот хөтөлбөрийг хавсралтаар батлах, 2 дахь заалтаар хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг даалгах, 3 дахь заалтаар Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, 4 дэх заалтаар шалгуур үзүүлэлт бүрэн тодорхойлох, 5 дахь заалтаар тогтоолыг дагаж мөрдөх хугацааны талаар тус тус тусгана.

Тогтоолын хавсралтаар батлах Хөгжлийн зорилтот хөтөлбөр нь 6 хөгжлийн зорилтот хөтөлбөртэй байхаар боловсруулах бөгөөд төслийн 1 дүгээр хавсралтаар Хүний хөгжлийн зорилтот хөтөлбөрийг, 2 дугаар хавсралтаар Нийгмийн хөгжлийн зорилтот хөтөлбөрийг, 3 дугаар хавсралтаар Байгаль орчны зорилтот хөтөлбөрийг, 4 дүгээр хавсралтаар Засаглалын зорилтот хөтөлбөрийг, 5 дугаар хавсралтаар Бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөрийг, 6 дугаар хавсралтаар Үндэсний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилтот хөтөлбөрийг тус тус батална.

Хүний хөгжлийн зорилтот хөтөлбөрт үндэсний нэгдмэл үнэт зүйлээ эрхэмлэн дээдэлсэн, эх оронч, ёс суртахуунтай иргэнийг төлөвшүүлэх, хүн амд эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлж, өвчлөл нас баралтыг бууруулах, боловсрол болон хөдөлмөрийн зах зээлийн нийцийг сайжруулах, боловсролын үйлчилгээний тэгш хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн зорилгыг тус тус тусган боловсруулна.

хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд тулгарах зөрчил, хийдэл арилж, хуулийг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй сөрөг үр дагавар арилна.

Хөгжлийн зорилтот хөтөлбөрүүд хэрэгжсэнээр 2030 он гэхэд Монгол Улсын нийгэм, эдийн засаг, байгаль орчин, засаглалын үзүүлэлтүүд дээшилнэ гэж үзэж байна. Тухайлбал, эдийн засгийн жилийн дундаж өсөлтийг 6 хувьд, хүний хөгжлийн индексийг 0.74-өөс 0.85, дундаж наслалтыг 70.2-оос 78 болгож нэмэгдүүлэх, ядуурлын түвшнийг 28.4-өөс 15 хувь болгож бууруулах, Засаглалын үр нөлөөг 45.7 хувиас 71.9 нэгж болгон өсгөх, үндэсний өрсөлдөх чадварын индексээр дэлхийд эзлэх эрэмбийг 20 байраар урагшлуулж, 82 дугаарт оруулах замаар бүтээмжийг нэмэгдүүлнэ. Түүнчлэн, өвчлөлөөс шалтгаалсан нас баралтын түвшинг бууруулах, хүнс, эмийн хангамжийн найдвартай, аюулгүй байдлыг дээшлүүлэх, орчны бохирдлыг бууруулахаар нөхцөлийг бүрдүүлэх ач холбогдолтой.

Дөрөв.Тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай уялдсан байдал, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаарх санал

Тогтоолын төслийг Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулах бөгөөд тогтоолын төсөлтэй холбогдуулан боловсруулах хууль тогтоомжийн төсөл байхгүй болно.

--- оОо ---

**“ХӨГЖЛИЙН ЗОРИЛТОТ ХӨТӨЛБӨР БАТЛАХ ТУХАЙ”
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН
ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 5 дугаар сарын 7-ны өдөр Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан. Тус хууль батлагдсантай холбогдуулан “Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2020 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн 45 дугаар тогтоолыг баталсан.

Энэхүү тогтоолын 1.2-т “Монгол Улсын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг энэ хуульд нийцүүлэн боловсруулж, Улсын Их Хуралд 2022 оны 6 дугаар сард багтаан өргөн мэдүүлэх”-ийг Засгийн газарт даалгасан.

Засгийн газраас Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого болох “Алсын хараа 2050”-ыг боловсруулж, Улсын Их Хурлын 2020 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор баталсан. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.5-д Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэхэд чиглэсэн Дунд хугацааны буюу 10 жилийн хугацаанд хэрэгжих хөгжлийн бодлогын баримт бичиг нь дараах Хөгжлийн зорилтот хөтөлбөр байна гэж заасан байдаг. Үүнд:

- 6.5.1.хүний хөгжлийн зорилтот хөтөлбөр;
- 6.5.2.нийгмийн хөгжлийн зорилтот хөтөлбөр;
- 6.5.3.эдийн засгийн болон дэд бүтцийн хөгжлийн зорилтот хөтөлбөр;
- 6.5.4.байгаль орчны зорилтот хөтөлбөр;
- 6.5.5.засаглалын зорилтот хөтөлбөр;
- 6.5.6.бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөр;
- 6.5.7.үндэсний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилтот хөтөлбөр юм.

Үүний дагуу Монгол Улсын дунд хугацааны Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төслийг боловсруулах Ажлын хэсгийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2021 оны 7 дугаар сарын 24-ний өдрийн 50 дугаар тушаалаар байгуулж, Монгол Улсад хөгжлийн зорилтот хөтөлбөр боловсруулах ажлыг анх удаа зохион байгууллаа.

Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төслийг боловсруулах хугацаанд Ажлын хэсэг 43 удаагийн уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, давхардсан тоогоор төрийн байгууллага, олон улсын байгууллага, иргэний нийгмийн байгууллага, эрдэмтэн судлаачдын төлөөлөл бүхий нийт 1,000 гаруй хүн төслийн хэлэлцүүлэгт оролцож, саналаа тусгаад байна.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг нь Монгол Улсын ирээдүйн 30 жилийн хөгжлийг тодорхойлсон, Монголын Эзэнт гүрний түүх, нүүдэлчин соёл иргэншил, үндэсний давтагдашгүй онцлогт суурилж, дэлхийн хөгжлийн дэвшилтэт үзэл баримтлалтай хослуулсан “Монгол хөгжлийн загвар” билээ.

"Алсын хараа-2050" нь 2030, 2040, 2050 он хүртэл 3 үе шаттайгаар хэрэгжих бөгөөд Хөгжлийн зорилтот хөтөлбөрүүдийг боловсруулахдаа "Алсын хараа-2050" урт хугацааны хөгжлийн бодлогод туссан эхний арван жилд хүрэх зорилго, зорилтуудыг бүх салбарын оролцоотойгоор хангахад чиглүүлж, нийгэм, эдийн засаг, байгаль орчны асуудлыг цогцоор авч үзэн, хөгжлийн үр шимийг иргэн бүрд тэгш, хүртээмжтэй хүргэх зарчмыг баримтлан боловсрууллаа.

Хөгжлийн зорилтот хөтөлбөр боловсруулах хүрээнд Засгийн газраас эдийн засаг, дэд бүтцийн хөгжлийн зорилтот хөтөлбөр болох Шинэ сэргэлтийн бодлогыг боловсруулж, Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 106 дугаар тогтоолоор баталсан. Энэ бодлогын хүрээнд эдийн засаг, дэд бүтцийн салбарын хөгжлийн хязгаарлагч хүчин зүйлүүдийг тодорхойлж, шийдвэрлэхээр зорьсон билээ.

Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төсөлд туссан зорилго, зорилт, үйл ажиллагааг тодорхойлохдоо Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн Тавдугаар зүйлд заасан зарчим, Аравдугаар зүйлд заасан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах үе шат болон Засгийн газрын 2021 оны 119 дүгээр тогтоолоор батлагдсан "Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах нийтлэг журам", Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2021 оны 42 дугаар тогтоолоор батлагдсан "Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах аргачлал"-ыг тус тус баримталсан. Дээрх төлөвлөлтийн үндсэн зарчмыг баримталж боловсруулснаас гадна дэлхий нийтийн бодлогын баримт бичиг болох Тогтвортой хөгжлийн зорилготой уялдуулсан болно.

Хөгжлийн 6 зорилтот хөтөлбөрийн хүрээнд 28 зорилго, 95 зорилт, 374 үйл ажиллагааг томьёолон тусгалаа. Хөгжлийн зорилтот хөтөлбөрүүдэд эрүүл чийрэг, эрдэм боловсролтой, бүтээлч иргэнтэй болох, шударга, ёс зүйтэй, хүмүүнлэг нийгмийг цогцлоох, хүн амын амьжиргааг дээшлүүлж, ядуурлыг бууруулах, тогтвортой өсөлт бүхий, мөчлөг сөрсөн эдийн засгийн суурийг бэхжүүлэх чиглэлээр бодитой үр дүн гарсан байх зорилт дэвшүүлээ.

Хөгжлийн зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлснээр 2030 онд эдийн засгийн жилийн дундаж өсөлтийг 6 хувьд хадгалах, хүний хөгжлийн индексийг 0.74-өөс 0.85 оноонд хүргэх, дундаж наслалтыг 70.7-оос 78 болгож нэмэгдүүлэх, мөн ядуурлын түвшнийг 28.4-өөс 15 хувь болгож бууруулах, засаглалын үр нөлөөний үзүүлэлтийг 45.7-оос 71.9 нэгж болгон өсгөх, үндэсний өрсөлдөх чадварын индексээр дэлхийд эзлэх эрэмбийг 20 байраар урагшлуулах, бүтээмжийг нэмэгдүүлэх зэрэг томоохон зорилтуудыг тусгалаа.

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д "Хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна." гэж, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5-т "Хөгжлийн зорилтот хөтөлбөр" гэж "Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тусгагдсан тодорхой зорилт, арга хэмжээг улсын хэмжээнд хэрэгжүүлэхээр салбар, салбар хоорондын болон бүс, орон нутгийн онцлогт нийцсэн, нөөцөд суурилсан, санхүүгийн эх үүсвэрээр баталгаажсан үйл ажиллагаа, тоон болон чанарын шалгуур үзүүлэлтийг тусгасан дунд хугацааны бодлогын баримт бичгийг" гэж, мөн хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.2-т "энэ хуулийн 4.1.5-д заасан баримт бичгийг

Засгийн газрын өргөн мэдүүлснээр Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэг, Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д заасныг тус тус баримтлан Улсын Их Хурал батлах” гэж заасан билээ.

Дээрх хуульд заасныг үндэслэн “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогод туссан эхний арван жилд хүрэх зорилго, зорилтуудыг хангахад чиглэсэн “Хөгжлийн зорилтот хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа. Тогтоолын төслийн 1 дүгээр хавсралтаар Хүний хөгжлийн зорилтот хөтөлбөрийг, 2 дугаар хавсралтаар Нийгмийн хөгжлийн зорилтот хөтөлбөрийг, 3 дугаар хавсралтаар Байгаль орчны зорилтот хөтөлбөрийг, 4 дүгээр хавсралтаар Засаглалын зорилтот хөтөлбөрийг, 5 дугаар хавсралтаар Бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөрийг, 6 дугаар хавсралтаар Үндэсний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилтот хөтөлбөрийг тус тус батална.

---o0o---

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны.... дугаар
сарын....-ны өдөр

Улаанбаатар
хот

Дугаар....

Хөгжлийн зорилтот хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9.2.2 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Хөгжлийн зорилтот хөтөлбөрийг дор дурдсан хавсралтаар баталсугай. Үүнд:
1.1.Хүний хөгжлийн зорилтот хөтөлбөрийг 1 дүгээр хавсралтаар;
1.2.Нийгмийн хөгжлийн зорилтот хөтөлбөрийг 2 дугаар хавсралтаар;
1.3.Байгаль орчны зорилтот хөтөлбөрийг 3 дугаар хавсралтаар;
1.4.Засаглалын зорилтот хөтөлбөрийг 4 дүгээр хавсралтаар;
1.5.Бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөрийг 5 дугаар хавсралтаар;
1.6.Үндэсний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилтот хөтөлбөрийг
6 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2."Хөгжлийн зорилтот хөтөлбөр батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилтийг хангаж, хуульд заасан дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусган ажиллахыг Монгол Улсын Засгийн газар (Л.Оюун-Эрдэнэ) болон холбогдох бусад байгууллагад үүрэг болгосугай.

3. Хөгжлийн зорилтот хөтөлбөр батлагдсантай холбогдуулан Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар (Л.Оюун-Эрдэнэ)-т даалгасугай:

1/Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрээр хангаж ажиллах;

2/Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн хэрэгжилтийг батлагдсан өдрөөс жигд ханган зохион байгуулж, түүний явцын тайланг 5 жил тутам, гүйцэтгэлийн тайланг тухайн баримт бичгийг дуусгавар болохоос нэг жилийн өмнө Улсын Их Хуралд танилцуулах;

3/Монгол Улсын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэх ажлыг зохион байгуулж Улсын Их Хуралд 2022 оны 12 дугаар сард багтаан танилцуулах.

4.Хөгжлийн зорилтот хөтөлбөрт туссан, одоо тооцох боломжгүй шалгуур үзүүлэлтийг тооцох аргачлал, суурь түвшин, зорилтот түвшнийг тодорхойлох ажлыг

2023 онд багтаан хэрэгжүүлэхийг Үндэсний статистикийн хороо (Б.Батдаваа) болон холбогдох бусад байгууллагад даалгасугай.

5.Энэ тогтоолыг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.